

УЛС ТӨР

“ДУНД ХУРУУ”-ТАЙ
МЭТГЭЛЦЭЭН

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ХОНХНЫ БАЯРЫН ЦАЙЛЛАГА
70-250 МЯНГАН ТӨГРӨГ БОЛДОГ

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Дугаарын 60 мөр

СЕХ гэж
сөнөчихсөн газар
байх юм

Б.ЭРХЭС

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болоход 40 хоногийн хугацаа үлдээд байна. Улс төрийн намууд нэр дэвшигчээ тодруулж, улмаар СЕХ-ноос нэрсийг нь өнөөдөр эцэслэн олон нийтэд зарлах учиртай. Төрийн тэргүүний сонгуульд өрсөлдөх улстөрчдөд тусгай үнэмлэх олгосноор төрийн тусгай хамгаалалтад авна. Энэ мэтээр хуулийн хүрээнд хийгдэх ажлууд шат дараатай эхэлжээ. Намууд ч хууль зөрчин нэр дэвшигчийнхээ талаар худал, үнэн нь үл мэдэгдэх мэдээ материал олныг цацаж байна. Гэхдээ хэвлэлээр биш. Сошиал сүлжээ идэвхтэй болсон энэ цагт иргэд ямар ч шүүлтүүр байхгүйгээр үнэн, худлыг үл мэдэх мэдээлэл авч байгаа юм.

Үргэлжлэл нь III нүүрт

ТОМИЛОЛТ



“НАМЧИРХАЛ, УЛСТӨРЖИЛТӨӨС ҮҮДЭЖ УУЛ УУРХАЙН САЛБАР ХӨГЖИЖ ЧАДАХГҮЙ БАЙНА”

Н.БАТЗАЯА

Монгол Улсын эдийн засгийн гол хөдөлгүүр уул уурхайн салбарын хөгжил тэртээ 1911 онд байгуулагдсан Налайхын уурхайгаас эхлэлтэй. Анх хүрз жоотуугаар хөдөлмөрийн зэвсэг хийж эхэлсэн уул уурхайн салбар 95 жилийн хугацаанд гүний уурхайн алсын зайн роботикийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх хэмжээнд хүртэл хөгжиж, 40 гаруй мянган хүнийг ажлын байраар хангаж буй томоохон

салбар. Энэ жил тус салбарын 95 жилийн ой тохиож байгаа бөгөөд салбар яамнаас олон ажлыг шат дараатайгаар зохион байгуулж байгаа аж. Үүний нэг нь “Уул уурхайн салбарын Төвийн бүсийн чуулган” юм. Энэхүү чуулга уулзалт өчигдөр Орхон аймагт болж өндөрлөлөө. Чуулга уулзалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, “Эрдэнэт үйлдвэр” ХХК хамтран зохион байгууллаа. Уулзалтад, УИХ-ын гишүүн Д.Дамба-

Очир, А.Ундраа, Н.Амарзаяа, УУХУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Орхон аймгийн ИТХ-ын дарга П.Пүрэвхагва, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн болон Архангай, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцлоо.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

Буцалтгүй тусламж БУРУУ ГАРААР орох вий

–БНХАУ эхний ээлжинд 350 сая, хоёр жилийн хугацаанд хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламж олгохоо мэдэгдлээ–

Б.ӨНӨРТӨГТӨХ

Улс төрийн өндөр албан тушаалтан, Төрийн гурван өндөрлөг гадны улс орнуудад айлчлал хийхээр мордох болгонд “одоо юу л гуйх бол” хэмээн хардаж, хүлээдэг болсноор багагүй хугацаа өнгөрчээ. Нөгөөдүүл нь ч очих болгонд биднийг гар хоосон буцаахгүй юм. Дипломат харилцаа өндөр төвшинд байвал буцалтгүй тусламж хэлбэрээр хэдэн төгрөг өгчихдөг. Үгүй юм аа гэхэд хоёр улсын Засгийн газар, эсвэл банк санхүүгийн байгууллагаараа дамжуулан хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгохоо амална. Манайхан ч түүнийг нь голно гэж байхгүй. Үнэгүй юманд нугасгүй гэгчээр өгч л байвал авч л байна. Дараа дараачийн үр дагаврыг нь тооцдог ч үгүй байх. Түүх сөхвөл, манай улс 1991 оноос эхлэн гадаадын зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл авч эхэлсэн аж. Улмаар 1991-2005 он хүртэл 144 төсөл хөтөлбөрийг гадны зээл тусламжаар хэрэгжүүлжээ. Тэгвэл энэ тоо сүүлийн таван жилийн хугацаанд хоёр дахин нэмэгдсэн байна. Төр засгийн өндөр албан тушаалтан, Төрийн гурван өндөрлөг очсон газар бүрээсээ зээл, эсвэл тусламж хүсдэг. Тэр болгонд гадныхан бидэнд тун ч уриалгахан зээл өгнө, эсвэл буцалтгүй тусламж хэлбэрээр хэдэн төгрөг өгчихдөг. Монгол Улсын нэр хүнд дэлхий дахинд үнэ хүндтэйдээ бус монголын газар нутагт байгаа асар их баялаг л тэдний алгаа тэнийх шалтгаан болдгийг худлаа гэж хэлэхгүй биз ээ.

Үргэлжлэл нь III нүүрт



Forbes MONGOLIA MONGOLIAN PROPERTY AWARDS ЗАЛУУСЫН ХОТХОН X Apartment ШИЛДГЭЭР ТОДОРЛОО



Дэлхийн 15 оронд хэвлэгдэн гардаг, санхүүгийн №1 Forbes сэтгүүлээс жил бүр шалгаруулдаг "MONGOLIAN PROPERTY AWARDS"-ын 2016 оны Үл хөдлөхийн шилдэгээр Залуусын хотхон "X Apartment" тодорч “Шилдэг орон сууц” өргөмжлөлийг хүртэн, дэлхийн орон бүрт тодруулдаг энэхүү нэр хүндтэй шагналын эзэн боллоо.

Залуусын хотхон “X APARTMENT” нь хотын төвөөс 4км зайд, нийслэлийн А зэрэглэлийн бүсэд байрлалтай бөгөөд Япон архитекторын орон зайн төгс шийдлээр, өрөө бүрт нарны гэрэл бүрэн тусахаар маш нарийн тооцсон зохион байгуулалтын өвөрмөц төлөвлөлт, 24 цагийн хүлээн авах ресепшн, Монтессори сургалттай цэцэрлэг, таны хэрэгцээг бүрэн хангах бүх төрлийн үйлчилгээг нэг дор бүрдүүлсэнээрээ бусдаас онцлог давуу талтай юм.



Стандарт загвар: 1 өрөө
30 - 32 мкв



Стандарт загвар: 2 өрөө
54 - 64мкв



Стандарт загвар: 3 өрөө
59.5 - 82 мкв



Дуплекс загвар: 2-4 өрөө
37.5 - 104 мкв

ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ ЯПОН БРЭНДҮҮДЭЭР “X APARTMENT”-ЫГ ТОНОГЛОЛОО

ГЕРМАН ВАКУМ ЦОНХ	ЯПОН САНГИЙН ТОНОГЛОЛ	СОЛОНГОС ОБОЙ	ЯПОН БУДАГ, ЭМУЛЬС	АВСТРИ ПАРКЕТАН ШАЛ	ГЕРМАН ЦАХИЛГААН ШАТ	ГЕРМАН ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ	MEGAWOOD ХААЛГА
-------------------	-----------------------	---------------	--------------------	---------------------	----------------------	------------------------	-----------------

Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд “УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ” ХХК

77009919, 96066329, 88002312, 88030203
www.xapartment.mn



ХААН банк			Хугалгаа хөгжлийн банк								
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2416.00	2426.00	ФУНТ	3081.00	3169.00	АМ.ДОЛЛАР	2420.00	2430.00	ФУНТ	3091.00	3163.00
ЕВРО	2625.00	2688.00	РУБЛЬ	42.10	44.10	ЕВРО	2629.00	2692.00	РУБЛЬ	41.83	44.93
ИЕН	21.22	21.48	ЮАНЬ	349.80	352.60	ИЕН	21.04	21.57	ЮАНЬ	350.00	352.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

МАХН-аас
С.Ганбаатар нэр
дэвшихээр болов

Б.ТОГТОХ

МАХН-ын Гүйцэтгэх товчоо өчигдөр хуралдан нэр дэвшигчээ тодруулсны дараа, үргэлжлүүлэн Бага чуулган хуралдсан юм. Бага чуулганд хэдэн гишүүн оролцсон талаар мэдээллийг мөн л сэтгүүлчдэд өгсөнгүй. Гүйцэтгэх товчооны хурлаар 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эсэхээр найман хүн дотооддоо өрсөлдөж, дөрвөн хүний нэр Бага чуулганд орж иржээ. Тодруулбал, Шадар сайд асан Ц.Оюунбаатар, Монгол Улсын гавьяат хуульч Ц.Шаравдорж, УИХ-ын гишүүн асан С.Ганбаатар, “Насны зам” компанийн захирал Ж.Энхжаргал нарын нэр дээр санал хурааж, тус намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулахаар болсон. Гүйцэтгэх товчооны хурлын үеэр зарим нь нэрээ татсан аж. Учир нь, Ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлэх хүн бүх зардлаа өөрөө гаргаж, намдаа хандив өгөх ёстой гэсэн шийдвэр гарсан байна. Тиймээс намд өгөх мөнгө байхгүй хэмээгээд хуульч С.Нарангэрэл нэрээ татсан гэх мэдээлэл байгаа. Бага чуулганаар дөрвөн нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг нэгбүрчлэн сонссоны дараа оройн 21.00 цагийн орчим шийдвэрээ гаргаж УИХ-ын гишүүн асан С.Ганбаатарыг нэр дэвшүүлэхээр болжээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“ДУНД ХУРУУ”-ТАЙ
МЭТГЭЛЦЭЭН

– Үндсэн хууль өөрчлөх асуудлыг намын дарга нар хэлэлцлээ –



Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар улс төрийн намуудын дарга, удирдлагууд, судлаачид, иргэний нийгмийн төлөөлгүүд оролцсон “Үндэсний зөвшилцөл” уулзалт өчигдөр Төрийн ордонд боллоо. Хэлэлцүүлгийг МАН-ын дарга, УИХ-ын дарга М.Энхболд нээж үг хэлсэн юм. Тэрбээр, “Энэ удаагийн УИХ ард түмний саналд үндэслэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нь зөв гэж ярилцаж байгаа. Сонгуулийн мөрийн хөтөлбөрт ч туссан. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудал энэ удаад яригдсан юм биш. Дөрвөн ч удаа УИХ-ын гишүүд Үндсэн хуулийг өөрчлөхөөр санал өргөн барьсан. Түүнчлэн, Засгийн газар эрдэмтэн судлаачдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гаргаж, Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлаар орон даяар судалгаа явуулсан. Улс төрийн намын оролцоогүйгээр зохион байгуулсан энэ арга хэмжээнд түүврийн аргаар сонгогдсон иргэдийн төлөөлгүүд хэлэлцүүлэг өрнүүлж, байр сууриа илэрхийлэн, санал асуулгад хамрагдсан. УИХ-ын даргын захирамжаар 26 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарчихсан ажиллаж байна. 2013 оноос хойш улс орны улс төр нийгмийн амьдралд тулгамдаж буй олон асуудлаар бид зөвшилцөл

хийсэн. Энэ удаад ч улс төрийн намуудтайгаа зөвшилцлийн ширээний ард сууж байна” гэв. Хэлэлцүүлэгт МНН-ын дарга О.Бум-Ялагч, МҮАН-ын дарга Б.Цогтгэрэл, МСДН-ын дарга А.Ганбаатар, дэд дарга Д.Энхзаяа, Ард түмнээ хайрлая намын дарга Л.Гүндалай, ТТЭНН-ын дарга Г.Уянга, Эх орончдын намын дарга Д.Ганбат нарын парламентад суудалгүй намын дарга нар болон парламентад суудалтай намын нөлөө бүхий улстөрчид оролцлоо. Хэлэлцүүлгийн эхэнд Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан түүврийн санал асуулга, мөн Төрийн ордонд зохион байгуулсан хэлэлцүүлгээс гарсан үр дүн, УИХ-д хүргүүлсэн зөвлөмжийн талаар ажлын хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан тайлбар өглөө. Тухайлбал, Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа Ерөнхий сайд Засгийн газрынхаа бүтэц бүрэлдэхүүнийг томилох асуудлыг шийдэх, УИХ-ын 76 гишүүний 19 буюу 4-ний 1 нь Ерөнхий сайдад хариуцлага тооцох асуудал тавьбалогцруулах, УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүдийн 3/2 нь үзсэн бол Ерөнхийлөгч УИХ-ыг тараах шийдвэр гаргана гэх мэт асуудлыг зөвшилцжээ. Мөн УИХ-ын анхдугаар чуулган хуралдсанаас 30 хоногийн дотор,

эсвэл Ерөнхий сайдын бүрэн эрх дуусгавар болсноос 21 хоногийн дотор Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол УИХ-ыг тараах зарлиг гаргахаас гадна таван яамны нэрийг Үндсэн хуульд тусгах санал олон хүний дэмжлэг авчээ. Засгийн газар нийт 12-13 яамтай байх нь зөв гэж Үндсэн хуулийг өөрчлөх асуудлаар зөвшилцөлд хүрсэн иргэд зөвлөмждөө тусгасан байна. Хэлэлцүүлгийн шатанд нэлээд шүүмжлэл өрнөв. Мөн парламентад суудалгүй улс төрийн намуудын дарга нар хоорондоо маргалдаж, Төрийн ордонд дунд хуруугаа гаргаж танхайрав. МНН-ын дарга О.Бум-Ялагчтай МСДН-ын дэд дарга Д.Энхзаяа гэх бүсгүй маргалдаж, улмаар Төрийн ордны танхимд дунд хуруугаа гаргаж танхайрлаа. Энэ нь өчигдөр цахим ертөнцөд шүүмжлэл дагуулж, улс төрийн соёл, төлөвшил байдхгүй энэ мэт хүмүүс Үндсэн хууль өөрчлөх тухай яриад сууж байж болох уу гэх хэлэлцүүлэг ч өрнөөд амжсан юм. Мөн өөрчлөх нь зөв буруу гэсэн маргаан ч гарлаа. Тухайлбал, ММН-ын дарга О.Бум-Ялагч үндэсний зөвшилцөл хууль зөрчиж явагдсан учраас Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг дэмжихгүй гэв. Нөгөөтэйгүүр, эхлээд дордохын долоон заалтаа

өөрчилчихөөд дараа нь өөрчлөлт ярих ёстой. Нийгэм эдийн засгийн өнөөгийн хямралт байдлыг Үндсэн хуулиа өөрчлөөгүйгээс болсон гэж би итгэхгүй байна хэмээлээ. Хэлэлцүүлгийн үеэр намуудын дарга нар байр сууриа илэрхийллээ.

Д.Хаянхярваа: Аль нэг намын эрх ашигт захирагдахгүй

/УИХ дахь, МАН-ын бүлгийн дарга/

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг аль нэг улс төрийн нам, хэн нэг албан тушаалтны эрх ашигт захируулж хийх ёсгүй. Энэ асуудалд ихээхэн ултай суурьтай хандаж, олон удаагийн уулзалт, хэлэлцүүлэг өрнүүлж, гарсан санал бодлыг анхаарч судлах болно.

Б.Цогтгэрэл: Засч залруулах зүйл байгаа

/МУАН-ын дарга/

Нэг нам УИХ-д 65 суудал авсан энэ үед Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нь түүхэн боломж. Энэ бол эрх баригч намын боломжоо ашиглаж хийх ёстой том ажил.

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

МАХН-аас
С.Ганбаатар нэр
дэвшихээр болов

Б.ТОГТОХ

МАХН-ын Гүйцэтгэх товчоо өчигдөр хуралдан нэр дэвшигчээ тодруулсны дараа, үргэлжлүүлэн Бага чуулган хуралдсан юм. Бага чуулганд хэдэн гишүүн оролцсон талаар мэдээллийг мөн л сэтгүүлчдэд өгсөнгүй. Гүйцэтгэх товчооны хурлаар 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эсэхээр найман хүн дотооддоо өрсөлдөж, дөрвөн хүний нэр Бага чуулганд орж иржээ. Тодруулбал, Шадар сайд асан Ц.Оюунбаатар, Монгол Улсын гавьяат хуульч Ц.Шаравдорж, УИХ-ын гишүүн асан С.Ганбаатар, “Насны зам” компанийн захирал Ж.Энхжаргал нарын нэр дээр санал хурааж, тус намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулахаар болсон. Гүйцэтгэх товчооны хурлын үеэр зарим нь нэрээ татсан аж. Учир нь, Ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлэх хүн бүх зардлаа өөрөө гаргаж, намдаа хандив өгөх ёстой гэсэн шийдвэр гарсан байна. Тиймээс намд өгөх мөнгө байхгүй хэмээгээд хуульч С.Нарангэрэл нэрээ татсан гэх мэдээлэл байгаа. Бага чуулганаар дөрвөн нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг нэгбүрчлэн сонссоны дараа оройн 21.00 цагийн орчим шийдвэрээ гаргаж УИХ-ын гишүүн асан С.Ганбаатарыг нэр дэвшүүлэхээр болжээ.

Л.Гүндалай: Таван яамыг нэрлэх нь зөв

/Ард түмнээ хайрлая намын дарга/

Тодорхой сэдвийн хүрээнд өөрчлөлт хийнэ гэвэл дэмжинэ. Таван яамыг Үндсэн хуульдаа тусгаж нэрлэх нь зөв гэж бодож байгаа. Засгийн газрын гишүүдийн гуравны нэг нь УИХ-ын гишүүн байх нь хэр оновчтой вэ. Үүнийг дахин ярилцаж, анхааралдаа авах хэрэгтэй. Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд мэргэжлийн хүнийг сайдаар томилдог болох хэрэгтэй. Манай нам зарчмын зургаан сэдвийг дэмжиж байна. Уг нь ийм асуудлыг санал асуулгаар шийдэж болохгүй л дээ. Удирдаж байгаа бол удирдсан шиг удирдаад, шийдээд явах ёстой юм.

Г.Уянга: Өөрчлөхийг дэмжихгүй

/ТТЭНН-ын дарга/

Үндсэн хуулийн өөрчлөлтийг яаран хийж болохгүй. Ард нийтийн санал асуулга явуулахыг ч дэмжихгүй байгаа. Үнэхээр өөрчлөхийг хүсч байгаа бол сум дүүрэг, хорооноос Үндсэн хуулийг өөрчлөх бүрэлдэхүүнийг сонгох ёстой. 500 гаруй депутат цутлана гэсэн үг. Тэгж байж л өөрчлөх тухай ярих болох юм. Цаг хугацаа ч байгаа. 2020 он хүртэл Үндсэн хуулийг өөрчлөх бүрэлдэхүүнийг эхлээд сонгох болно.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

БОАЖЯ хэмнэлтийн горимд шилжжээ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол салбарын хүрээнд төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх тушаал гаргав. Үүнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа байгууллагууд дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нарт дараах үүргийг хүлээж байна. Тухайлбал,

төрийн албан хаагчийн зэрэг, дэв ахиулах шийдвэрийг 2019 оныг дуустал гаргахгүй байх, ирэх оны арванхоёрдугаар сарын 31-нийг хүртэл өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчийн оронд нөхөн томилгоо хийхгүйгээр ажигтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн оновчтой тогтоохыг даалгасан байна.

Хөдөлмөрийн хуулийг шинэчлэх нь
нийгмийн захисалга гэв

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран өчигдөр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл-ийг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулсан юм. Хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр нээж үг хэллээ. Тэрбээр “Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн тухай хууль 1999 онд батлагдсанаас хойш хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд зарчмын өөрчлөлтүүд гарч, шинэ чиг хандлага бий болсноос үүдэн уг хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага гарч байна” гэв. Мөн хуулийн үр нөлөөг дээшлүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор ажил олгогч, эрдэмтэн судлаачдын санал бодлыг сонссоны үндсэн дээр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын

төслийг боловсруулж Та бүхэнд танилцуулж байна” хэмээн сайд Н.Номтойбаяр онцолсон юм. Дараа нь УИХ-ын гишүүн, НББСПУ-ны байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан үг хэллээ. Тэрбээр “Өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 70 хувийг хуурын хэвшил бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, хуурын хэвшилд тулгуурласан зүв эзэлийн эдийн засагт бид шилжсэн. Нийгмийн захиалгаар Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага бий боллоо. Улс орноо тогтвортой хөгжүүлэе гэвэл тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох хэрэгтэй. Үүний тулд хөдөлмөр эрхлэлтийн зөв механизмыг бий болгох ёстой юм” гэв. Хэлэлцүүлгийн үеэр Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо уг хуулийн төсөлтэй холбогдуулан байр сууриа илэрхийлж байлаа. Мөн хэлэлцүүлэгт оролцогч ажил олгогчид өөрсдийн байр сууриа илэрхийлж, санал бодлоо хэлсэн юм.

Худалдаа хөгжлийн банк дампуурах талаар ташаа
мэдээлэл тараажээ

Б.ТУЛГА

Олон нийтийн сүлжээгээр Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн нэр, зургийг ашигласан “Б.Чойжилсүрэн Сангийн сайд” гэсэн хуурамч хуудаснаас “Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа Худалдаа хөгжлийн банк дампуурлаа зарлана” хэмээн худал мэдээллийг өчигдрөөс тарааж эхэлсэн билээ. Тодруулбал, Сангийн сайдын зураг бүхий хаягнаас “ХХБ-ны санхүүгийн байдал хүндэрсэн. Хүндэрсэн шалтгаан гэвээс Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг Оросуудаас авахын тулд ХХБ болон Улаанбаатар банкаас хадгаламж эзэмшигчдийн 500 сая ам.долларыг гаргасан” хэмээн бичсэн байсан юм. Тэгвэл энэхүү ор үндэстгүй мэдээллийг Сангийн яамны зүгээс албан ёсоор няцааж, Б.Чойжилсүрэн сайд мэдээлэл өгөв. Сангийн сайдын зүгээс 2017 оны тавдугаар сарын 15-ны өдрийн УИХ дахь МАН-ын бүлгийн хуралдаанд Худалдаа, хөгжлийн банк болон бусад банктай холбоотой ямар нэг мэдээлэл хийгээгүй бөгөөд Худалдаа, хөгжлийн банкнд аливаа эрсдэл учраагүй гэв. Тэрбээр, “Арилжааны ямар нэгэн банктай холбоотой мэдээлэл бүлгийн хуралд өгөөгүй. Бүлгийн хуралд 33-аас олон гишүүн байсан.

Тэд ийм зүйл болоогүй гэдгийг албан ёсоор баталж байна. Яагаад энэ няцаалтыг хийж байгаа вэ гэвэл банкны салбар эмзэг, итгэл, хүлээлт дээр тогтдог. Худалдаа Хөгжлийн Банк манай арилжааны том банкуудын нэг. Ийм зүйл болоогүй

гэдгийг та бүхэнд албан ёсоор мэдээлж байна. Надад албан ёсны хаяг сошиалд байхгүй. Сонгууль болохоор ийм хуурамч хаяг нэмэгддэг. Сангийн яамнаас хуурамч мэдээлэлтэй холбоотой албан ёсоор хууль хяналтын байгууллагад хандсан. Өчигдөр гарсан мэдээллийн няцаалтыг маргааш нь хийж байгаа учраас бодит хохиrol нь гайгүй байх. ХХБ хуулиараа Монголбанкнаас тавигдаж буй шаардлагуудыг хангаад явж байгаа. Сүүлийн жилүүдэд цахим технологи, олон нийтийн сүлжээ хурдацтай хөгжиж, аливаа мэдээлэл баримт нотолгоогүйгээр тархах бололцоотой болсон. Иймээс сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудад үндэслэлгүй худал мэдээллийг хэвлэн нийтлэхгүй, олон нийтийн сүлжээ хэрэглэгчид түгээхгүй, иргэддээ худал мэдээлэлд автахгүй байхыг хүсч байна” гэв. Мөн энэ үеэр ОУВС-ийн захирлуудын зөвлөлийн шийдвэр хэзээ гарах талаар сэтгүүлчид тодруулав. Сангийн сайд “Ирэх Лхагва гарагт ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн хурлаар манай асуудал хэлэлцэгдэнэ. Нийт санхүүжилтийн хэмжээ 5.5 тэрбум доллар болж байгаа. Валютын сан өөрөө 440 орчим сая долларын тусламжийг 15 жилийн хугацаатайгаар олгоно. Тавдугаар сарын 24-ний өдөр захирлуудын зөвлөл хуралдахаа мэдэгдсэн. Олон нийтийн дунд эдийн засгийн эрх мэдлээ гадаадад шилжүүлээ гэсэн асуудал явж байгаа. Энэ хөтөлбөрт хамрагдсанаар эдийн засгийн ямар нэг эерэг нөлөө үзүүлнэ” гэлээ. Мөн ХХБ-ны асуудлаар Монголбанк ч мэдээлэл гаргалаа.

ҮЗЭЛ БОДОЛ

БҮЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ БУРУУ
ГАРААР ОРОХ ВИЙ

Дугаарын 60 мөр

СЕХ гэж сөнөчихсөн газар байх юм

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Нөгөөтэйгүүр, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар ирц хүрэх үү гэдэг нь юу юунаас илүүтэй санаа зовних асуудал. Жилийн жилд сонгуулийн ирц хангалтгүй болж байгаа. Иргэдийн төрд итгэх итгэл буурч, сонгуулийн өдрийг бүх нийтийн амралт шиг тэмдэглэх болсон нь худлаа биш. Өнөө жил ч ийм хандлага гарч байх юм. Сонголтгүй сонгууль учраас саналаа өгөхгүй гэсэн уриалга цахим ертөнцөд гарч байна. Тэгвэл энэ асуудалд СЕХ анхаарал хандуулах учиртай. Сонгууль зохион байгуулах төв байгууллагын нэн тэргүүний үүрэг бол ирц хангалттай байлгах. Мөн шат шатны сонгуулийг элдэв хэл ам, хэрүүл маргаангүй зохион байгуулах явдал. Харамсалтай СЕХ энэ үүргээ хангалттай биелүүлэхгүй байна. Сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалж, Төрийн тэргүүнээ сонгох нь бидэнд яагаад чухлыг тэд сурталчилж байгаа зүйл алга. Хэвлэл мэдээллээр энэ талаар мэдээлэл бэлтгэж хүргэх, сонгууль өгөх дургүй хэсэг бүлэгт хүрэх нөлөөллийн ажлаа ч эхлүүлэх ёстой баймаар. Гэтэл “дүүрчихсэн тэнэг”-үүд л энэ байгууллагад ажиллаж байна гэхэд хатуудахгүй. Ганц нэгхэн хэвлэлд 4/1 хэвлүүлсэн гээд сурталчилгаа болохгүй. Сошиал сүлжээ, тв, сонин, сэтгүүл гээд бүх байгууллагаар нөлөөллийн ажлаа хийж байж иргэдийн сонгуулиа өгөх идэвх нэмэгдэх учиртайг олон жил СЕХ-г удирдсан Ч.Содномцэрэн дарга мэдмээрсэн. Төсөв мөнгө ч хангалттай бий. Шат шатны сонгууль зохион байгуулахад зарцуулах мөнгийг жил бүхэн тэрбумаар нь баталдаг. Өнөө жил ч 2017 оны төсвийн тухай хуулиар Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлыг 14.9 тэрбум төгрөгөөр баталж өгсөн. Энэ нь 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн зардиас тэрбум орчим төгрөгөөр бага ч гэсэн хангалттай мөнгө. Сонгууль зохион байгуулах зардал, техник тоног төхөөрөмжийн бэлтгэл, самбар, тараах материал, ажлын хэсгийн цалинг хангалттай тавьж хүрэлцэхүйц мөнгө. Хэдхэн сая төгрөг биш хэдэн тэрбумаар яригдаж байгаа шүү. Тиймээс хэвлэл мэдээлэлд зарцуулах хэдэн сая төгрөг үлдээгүй гэдэг юу л бол. Үгүй ядахдаа, иргэдийнхээ сонгууль өгөх идэвхийг нэмэгдүүлэхийн тулд нэгж, киноны тасалбар өгөх зэргээр урамшуулж яагаад болохгүй байна вэ. Тун сайхан БНСУ Ерөнхийлөгчөө сонголоо. Өмнөх Ерөнхийлөгч нь хугацаанаасаа өмнө огцорч нөхөн сонгууль болох үеэр Солонгосын телевизүүдээр сонирхолтой, иргэдийг уйдаахгүй нэвтрүүлэг хүртэл бэлтгэн хүргэж байлаа. Санал тоолох явцад иргэд уйдаахгүйн тулд танин мэдэхүйн болон хөгжөөнт нэвтрүүлэг үүзж цагаа өнгөрөөж байсан юм. Энэ мэт жижигхэн юм шиг боловч нөлөөлж чадах зүйлээс бид яагаад суралцаж болохгүй байна вэ. Нэр дэвшигчийн талаар хөнгөн чөлөөт мэдээлэл бэлтгэж сошиалд хүргэх, сонгуулиа өгч байгаа иргэдийн хөгжилтэй, эсвэл залууст сургамж болох нэвтрүүлэг, эсвэл хөөрхөн реклам ч хийж болно. Гэтэл төрийн цагдаа гаднаа зогсоочихоод л Төрийн ордон шиг л хамгаалалт гаргаж сүйд болох юм. Нэвтрэх гэсэн хүмүүсийг нэгбүрчлэн шалгаж, ард түмнээсээ улам бүр л алсраад байх юм, тэд. Цаг үеэ мэдэрч ажиллаж байгаа хүн тэнд алга. Хатуухан хэлэхэд, даргатайгаа хамт ажлын аппарат нь “өвгөрчихөж”. Мэдээллийн эрин үед бид хаашаа явж байгааг мэдэрч, тэнд хүрч ажиллаж чадахгүй бол ажлаа өгвөл зүгээрсэн. Хийж чадах хүн олон бий. Улс төрийн намуудын шахааны хүмүүс СЕХ-ны гишүүнээр ажилладаг. Тэд ч гэсэн төрийн мөнгийг зүгээр идэж суухаар СЕХ-ны гишүүний үндсэн үүргээ биелүүлж болохгүй юу. Шат шатны сонгуулиар ирц буурч буйн шалтгааныг СЕХ-ноос эрэх учиртай. Тэд нөлөөллийн ажлаа хийж чадахгүй байна. Хэвлэл мэдээлэлд цензур тогтоож, төсөвлөсөн мөнгөө буруу зүйлд зарцуулаад байгааг хянаж шалгамаар байна, улстөрчид өө. Хөндлөнгийн аудит оруулвал яасан юм. Хэлтэй, амтай сонгууль зохиох нь ганц хийдэг ажил нь биш байлтай.

–БНХАУ эхний ээлжинд 350 сая, хоёр жилийн хугацаанд хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламж олгохоо мэдэгдлээ–

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ерөнхий сайд мөнгө гуйхаар явсан уу, эсвэл...

Энэ сарын 12-15-нд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат БНХАУ-д анх удаа айлчилсан. Айлчлах тухай яриа гарангуут л энэ удаад хэдэн төгрөгийн зээл тавих бол гэсэн хардлага байсныг нуух юун. Гэвч, Гүйцэтгэх засаглалын тэргүүний айлчлал гуйлга, ашиг хоёрыг хослуулж чаджээ. Тодруулбал, Хятад улсын дарга Си Зиньпиний санаачилсан “Бүс ба зам” олон улсын дээд төвшний чуулга уулзалтад оролцож Монголын сонирхлыг уламжилан, мөн тус улсын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көцянтай албан ёсны хэлэлцээ хийж, 21 төсөл хөтөлбөрийг хувийн хэвшил болон Засгийн газрын төвшинд хамтран хэрэгжүүлэхээр ярилцсан нь энэ удаагийн айлчлалын хамгийн том олз байв. Далай ламын айлчлалаас болж хоёр улсын харилцаа таагүй, улмаар хөнгөлөлттэй зээлээ хойшлуулсан, БНХАУ-ын Чалько компанид өрөө төлсөн ч нүүрсээ 50 гаруйхан ам.доллараар гаргасаар байгаа зэрэг олон тодорхойгүй асуудлыг Ерөнхий сайд цэгцлээд ирэх болов уу гэсэн хүлээлт байлаа. Бүгдийг нь цэгцэлж чадаагүй ч 48 цагийн айлчлал үр дүнгээ тодорхой хэмжээнд өгчээ. Нөгөөтэйгүүр энэ айлчлалын хүрээнд БНХАУ-аас олгох нэг тэрбум ам.долларын зээлийн Хятадын талын хариуцах санхүүжилтийн харьцаа 85 хувь байсныг 95 хувьд хүргэхээр шийдвэрлэсэнээ Си Зиньпин дарга мэдэгдсэн. Мөн тус улсын Ардын банк Монголбанк хооронд байгуулсан спов хэлэлцээрийг сунгахаар тохирсон гээд чихэнд чимэгтэй мэдээ олон дуулдлаа. Гэвч энэ бол зээл гэдгийг мартаж боломгүй. Мөн зээлийн 95 хувь буюу 950 сая ам.долларыг хаашаа, хэрхэн зарцуулахаа өмнөд хөрш өөрсдөө шийднэ. БНХАУ-тай таагүй уур амьсгалаа зөөлрүүлсэн, улмаар “холын саднаа бус ойрын хөршөө түшнэ” хэмээн сануулсан Си даргын үгийг бид тун овжин ашиглах учиртай юм. Олон улсын анхаарлыг зүй

ёсоор татаж буй “Бүс ба зам” төслөөс Монгол Улс, БНХАУ-тай адилхан хожих учиртай. Тэгэхийн тулд өргөн, нарийн цариг гэсэн улстөржилтөө хойш тавьж энэ том төсөл хөтөлбөрийн нэгэн амин сүнс, “Эдийн засгийн коридоор” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь чухал байгаа юм. Ерөнхий сайд энэ удаад “гуйлга гуйсан” ч бас харилцан ашигтай хамтын ажиллагааг орхигдуулаагүй нь эндээс харагдаж байна. Тус улсын манай улсад “талтай” гэдгээ харуулсан дараагийн нэг шийдвэр нь өнөөх л бидний дурладаг буцалтгүй тусламж. Эхний ээлжинд өмнөд хөрш 350 сая юанийн буцалтгүй тусламж үзүүлэхээ мэдэгдэж, улмаар хоёр жилийн хугацаанд хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламж үзүүлэхээ мэдэгдсэн нь эдийн засагт улаан гэрэл асчихсан энэ үед яах аргагүй чихэнд чимэгтэй мэдээ байсныг нуух юун.

Зарцуулалт нь тодорхой бус зээл, буцалтгүй тусламж хэрээс хэтэрлээ

Гэвч буцалтгүй тусламж бүрийг бид алгаа ташаад аваад байж боломгүй. Үнэгүй зүйл зөвхөн хулганы хавхаанд байдаг гэгчээр хоёр жилийн хугацаанд олгох хоёр тэрбум 350 сая юанийн цаана ямар том эрх ашиг нуугдаж байгааг тоохгүй өнгөрч боломгүй. Уул уурхайн том төсөл үү, эсвэл өөр ямар нэг тохироо байсан уу гэдгийг одоогоор хэлэх боломж алга. Хариу нэхээгүй тус цөөхөн байдгаас хойш энэ их мөнгөний хариуг бид хэзээ нэг өдөр төлж л таараа. Тэр нь том орд газар ч байж мэдэх. Нөгөө талаар, буцалтгүй тусламжийг юунд зарцуулах нь одоогоор тодорхой бус байгаа. Өмнө нь ч тодорхой байгаагүй. 1991 оноос хойш авсан 26 жилийн зээл, буцалтгүй тусламжийн дийлэнх олонхи нь дандаа буруу зарцуулагдсан тоон мэдээ байна. Сангийн яамны өгсөн тооноос зөрдөг, эсвэл зарцуулалтаа буруу хийдэг, хаана юунд зарцуулсан нь мэдэхгүй алга болох нь манайд хэвийн үзэгдэл. Хамгийн сүүлд гэхэд, Кувейт улсаас өгсөн 12 сая ам.долларын буцалтгүй тусламжийг

хэрхэн зарцуулах талаар маргаж суусаар буцаах шахсан. Төрийн ордоноо шинэчилж барих гэж хэсэг бүлэг нь зүтгэлээ. Сүүлдээ Түлэнхийн төв барихад зарцуулах шийд гарч, хамгийн сүүлд хүүхдийн эмнэлэг барихаар болж асуудал намжсан. Тэгвэл БНХАУ-аас авах буцалтгүй тусламжийг УИХ-аар хэлэлцэх явцад юунд зарцуулах нь тодорхой болох юм билээ. Зарим эдийн засагчид Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөхөн орж ирэх 350 сая юанийн тусламж халамж хэлбэрээр тараагдах вий гэсэн болгоомжлол байгаагаа нуухгүй байна. Сонгууль болгоны өмнө л бэлэн мөнгө тарааж, амлалт өгдөг нь намуудын хувьд бичигдээгүй хууль болсон. 2016 оны УИХ-ын сонгуулийн өмнөхөн эрх баригч АН-ынхан Тавантолгойн хувьцааг бэлэн мөнгөөр тарааж “тансагласан”. Чингис бондын мөнгөө хий дэмий үрж орхиод, буцааж төлж чадахгүйд хүрсэн нь худлаа биш. Аргаа барахдаа Олон улсын валютын санд засгийн эрхээ атгуулчихаад тэдний захиалсан хөгжмийг тоглож суугааг худлаа гэж хэлэхгүй биз ээ. Тиймээс зарцуулалт нь тодорхой бус 350 сая юан сонгуулийн үеэр бэлэн мөнгө хэлбэрээр тараагдаж, эсвэл санал худалдаж авахад зарцуулах вий гэсэн болгоомжлол байгаа юм. Тэр тусмаа МАН халамжийг чухалчилдаг үзэл баримтлалтай. Хэдийгээр улс орны амьдрал хэцүү байна хэмээдэг ч орд газраа барьцаанд тавьчихаад иргэддээ бэлэн мөнгө тарааж байсан гашуун туршлага тэдэнд бий. Хэнд ч хардах эрх байгаа. Монгол Улсын сүүлийн таван жилийн хугацаанд авч байгаа буцалтгүй тусламж, гадны зээл ихэвчлэн байгаа онохгүй явж иржээ. АН эрх барьж байхдаа Чингис бонд авч гудамж, зам засаад өнгөрсөн гэж шүүмжилдэг нь үнэний ортой. Их хаадынхаа нэрээр барьцаалсан бондын мөнгө замын боржур, цэцэг, төсвийн үрэлгэн зардлыг нөхөхөд зарцуулагдаж, өнөөдөр эргэн төлөлт хийх мөнгөгүй болж, улмаар гадны улс орнуудаас “гуйлга” гуйж сууна. Үргүй зарцуулалт МАН-ыг эрх барьсан үед ч өөрчлөгдсөнгүй. Энэтхэг, Турк, Япон, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, БНСУ-ын Эксим банк, Олон улсын валютын сангаас хэдэн зуун сая, цаашлаад

тэрбум, тэрбум ам.долларын зээл авах гэрээ хэлцэл өнөө маргаашгүй хийгдэх нь тодорхой болсон. /чуулганаар хэлэлцээд эхэлчихсэн байгаа/ Харамсалтай нь эдгээр зээлүүдийн тун цөөхөн нь бүтээн байгуулалтад зарцуулагдана. Энэтхэг улсаас авах нэг тэрбум ам.доллар Газрын тосны үйлдвэр барихад зарцуулагдах юм билээ. Харин Валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хэлэлцээрт хамрагдсанаар Монголбанкны валютын нөөцийг нэмэх гэнэ. БНСУ-ын Эксим банкны 500 сая ам.долларыг боловсрол, эрүүл мэнд, хөдөө, аж ахуй, ипотекийн зээлийг санхүүжүүлэхэд ашиглах аж. БНТУ-ын Эксим банкаас авах 300 сая ам.долларын зээл мөн л хөдөө аж ахуйн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулагдана хэмээсэн ч өнөөдрийг хүртэл энэ салбарт дорвитой том ажил эхлээгүй, бүгд цаасан дээр байгаа. Азийн хөгжлийн банкны 900 сая ам.доллар болон Дэлхийн банкны 600 сая ам.доллараар төсвийн алдагдлыг санхүүжүүлж, Япон улсаас авах 850 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 2017, 2018 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зарцуулна гэдгээ Сангийн сайд мэдэгдлээ. Эндээс харахад зээлийн зарцуулалт хэт ерөнхий, бүтээн байгуулалт гэхээс илүүтэй дандаа алдагдлыг нөхөхөд зарцуулагдаж байна. Ийм байхад эдийн засаг сэргэх нь, ногоон гэрэл аслаа гэх мэт хий дэмий улс төрийн шоу, оноо авах гэсэн хийрхэл хэрэгтэй юм. Монгол Улсын төсвийн алдагдал 2017 оны эхний дөрвөн сард 285.5 тэрбумд хүрсэн статистик мэдээг өчигдөрхөн танилцуулав. Эдийн засаг нь өссөн ч төгрөгийн ханш 20 хувиар суларсан таагүй мэдээг ч тэд дуулав. Банкны хэмжээнд чанаргүй зээл өсч, иргэдийн худалдан авах чадвар муудсаар байхад эхлээгүй хэдэн төсөл хөтөлбөрт гарын үсэг зурчихаад эдийн засаг сэргэчихлээ хэмээн шуудах хэрэггүй л байлтай. Буцалтгүй тусламжаа ч гэсэн бүтээн байгуулалтад, үгүй ядахдаа сургууль цэцэрлэг барих зэрэг бодит зүйлд зарцуулж, авсан зээлээ ашигтай эргэлдүүлж чадаж гэмээнэ эдийн засгаа эрүүлжүүлж, ногоон гэрэл асаачихлаа гэж шуудаж бололгүй яахав.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

УИХ-ын гишүүн
Я.Санжмятав

“...ᠶᠢᠭ ᠳᠠᠠᠠᠳᠡᠡᠢ ᠡᠳ ᠳᠣᠳᠡᠭᠢ ᠨᠢᠠᠳᠣᠡᠡᠢ ᠠᠠᠳᠠᠠ 23 ᠢᠶᠢᠠᠠᠢ ᠳᠣᠳᠡᠡᠢ ᠠᠡᠠᠠᠢ ᠳᠠᠠᠠ÷ ᠳᠣᠳᠡᠡᠢ ᠠᠡᠠᠠᠢᠠᠠᠨ ᠳᠠᠡᠠᠠᠠᠨᠠᠢ, ÷ᠡᠡᠡᠡᠡᠡᠢ ᠳᠣᠳᠠᠡ ᠳᠣᠳᠡᠡᠢ ᠠᠡᠠᠠᠢᠤ ᠴᠠᠡᠡᠡᠡᠢ ᠳᠠᠡᠡᠠᠢᠠ ᠠᠳᠣᠳᠠᠨᠠᠢ ᠠᠠᠡᠢᠠ ᠡᠭᠤ. ᠓ᠠᠢᠳᠣᠢᠡ ᠳᠣᠨᠢᠶᠠ ᠢᠦ ᠳᠣᠳᠠᠶᠠᠳᠣ ᠠᠠᠳᠨᠠᠢ ÷ ᠠᠡᠡᠡᠢᠳ ᠢᠦ ᠢᠠᠢᠤᠢ ᠳᠠᠳᠣᠶᠠᠡᠡᠠᠠᠳ ᠠᠡᠡᠠᠠᠨ ᠳᠠᠡᠠᠠᠠᠨᠠᠢ ᠢᠦ ᠵᠢᠶᠢ...”

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

ДЭЛХИЙ

Мафын бүлэглэл нэртэй сэтгүүлчийн аминд хүрлээ

Мексикийн баруун хойд этгээдэд олон жилийн турш үйл ажиллагаа явуулж буй хар тамхины бүлэглэлийн тухай сурвалжлага бэлтгэсэн алдартай сэтгүүлч Жавьер Валдез бусдад буудуулан амь үрэгджээ. Тэрээр сүүлийн 10 гаруй жил олны анхаарал татсан сэдвээр эрэн сурвалжлах бүтээл хийж, “Франц пресс” агентлагт нийлүүлж байсан аж. Талийгаач Мексикийн Синалоа мужийн нийслэл Кулиакан хотын иргэн бөгөөд тэндээ өөрийн долоо хоног тутмын мэдээллийн сэтгүүл эрхлэн гаргадаг байсан байна. Гэвч, энэ сарын 15-нд сэтгүүлийн редакцийнхаа өмнө буудуулан амиа алджээ. Албаны эх сурвалжийн мэдээлснээр хар тамхины

наймаа, хүчирхийлэл, авлига хээл хахуульд нэрвэгдсэн Мексикт энэ он гарсаар дөрвөн сэтгүүлч гэмт бүлэглэлийн гарт амиа алджээ. Харин Жавьер Валдез тав дахь нь болж байгаа юм. Тэрээр амь сэрүүн ахуйдаа “Сэтгүүлч байна гэдэг хар тамхины бүлэглэлийн хар жагсаалтад орохтой адил юм” гэж хэлж байжээ. Францын нийслэл Парист төвтэй “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагын мэдээллээр, Мексикт 2000 оноос хойш 102 сэтгүүлч алагдсан бол өнгөрсөн жил мөн 11 сэтгүүлч гэмтэж бэртэн, амь насаараа хохирсон тохиолдол гарчээ. Энэ нь иргэний дайн үргэлжилж буй Сири, Афганистаны дараа орох үзүүлэлт юм.

НҮБ Пхеньяны эсрэг нэмэлт хориг арга хэмжээ авч магадгүй



НҮБ-ын Аюулгүйн зөвлөл хуралдаж, Хойд Солонгос шинэ төрлийн пуужин туршсан явдлыг эрс шүүмжилсэн мэдэгдэл хийлээ. Улмаар тус улсын эсрэг авсан бүх арга хэмжээг хэрэгжүүлэхийг бусад улс орнуудад уриалсан байна. Мөн Солонгосын хойгийн нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж, цаашид нэмэлт хориг арга хэмжээ авахаа илэрхийлжээ. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийнхөн Пхеньян Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгохыг эрмэлзэж буйгаа тодорхой алхмуудаар илэрхийлэх шаардлагатайг ч тэмдэглэсэн аж. Түүнчлэн, хойгийн хурцадмал байдлыг намжаах алхам хийх нь чухал

байгааг мэдэгдэлдээ онцолсон байна. Энэ мэдэгдэлтэй нь холбоотойгоор Аюулгүйн зөвлөл урьдын адил анхааруулж, шахаж шаардсан мэдэгдэл төдийгөөр Умардын пуужингийн туршилтад хариу барилаа гэх шүүмжлэх нэгэн ч байна. Мэдэгдэл биш тогтоол гаргасан ч, Хойд Солонгос дагаж биелүүлэхгүй нь тодорхой гэдгийг сануулах ажиглагчид ч байгаа юм. Гэхдээ Аюулгүйн зөвлөл энэ удаагийн хуралдаанаараа Пхеньян дахин цөмийн болон баллистик пуужингийн туршилт хийвэл тус улсын эсрэг бодитой арга хэмжээ авна гэдгээ тодорхой илэрхийлсэн гэдгийг эх сурвалжууд онцолж байгаа юм.




ТРАМП ОХУ-Д НУУЦ МЭДЭЭЛЭЛ ЗАДРУУЛСАН ГЭВ

Б.ДАВАА

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп ОХУ-д тагнуулын нууц мэдээлэл задруулсан тухай орон нутгийн өдөр тутмын хэвлэл мэдээлж, дуулиан шуугиан тарьж эхэллээ. Тус улсын “Вашингтон пост” сонины даваа гарагийн дугаарт Ерөнхийлөгч Доналд Трамп өнгөрсөн долоо хоногт Цагаан ордонд ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров, ОХУ-аас тус улсад суух Элчин сайд Сергей Кислайк нарыг хүлээн авч уулзахдаа хэт даврагч Лалын улс бүлэглэлтэй холбоо бүхий маш нууц мэдээллийг задруулсан тухай мэдээлэл нийтлэгджээ. Ингэхдээ нэрээ нууцалсан АНУ-ын эрх бүхий албан тушаалтны ярилцлагаас иш татсан байна. Тодруулбал, тус нийтлэлд нэрээ нууцалсан эх сурвалж “Ерөнхийлөгч Доналд Трамп зарим холбоотон орнуудынхаа эрх баригчдад ч хэлээгүй нууц мэдээллээ ОХУ-ын Элчин сайдад задруулсан” хэмээн ярьсан байна. Түүний хэлснээр, Гадаад хэргийн сайд Сергей Лавров, Элчин сайд Сергей Кислайк нар АНУ-ын Тагнуулын байгууллагын дүн шинжилгээ хийж боловсруулсан төрийн онц нууцад хамаарах баримт мэдээллийг уулзалтын үеэр Д.Трампаас авч, нутаг буцсан гэнэ. Мөн нийтлэлд хэд хэдэн эх сурвалжийн эшлэлийг нийтэлсэн байх бөгөөд тэдний дунд “Трамп баримтын эх хувийг гаргаж, нисэх онгоцонд зөөврийн компьютер ашиглахтай холбоотой хэт даврагч бүлэглэлийн

сүрдүүлгийн талаар дэлгэрэнгүй ярьж эхэлсэн” гэх мэдээлэл ч байх юм. Үнэн хэрэгтээ дээрх нууц мэдээллүүд зөвхөн АНУ-ын холбоотон улсуудад л хамаарах бөгөөд ОХУ-ын Засгийн газарт задруулах шаардлагагүй байсан гэнэ. Хэрэв тэдгээр мэдээлэл нийтэд ил болбол, тагнуул болоод терроризмын эсрэг хамтын ажиллагааны амин чухал итгэлцэл алдагдах эрсдэлтэй гэдгийг онцолжээ. Тэгвэл “Вашингтон пост” сонины нийтлэлийн мөрөөр Цагаан ордноос мэдэгдэл хийж, дээрх мэдээлэл ор үндэслэлгүй хэмээн няцаалт хийгээд амжсан байна. Тодруулбал, Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зөвлөх Х.Р.МакМастер, Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон нар мэдэгдэл хийсэн байна. Тэд Ерөнхийлөгч Д.Трамп ОХУ-ын

Гадаад хэргийн сайд Сергей Лавровтой уулзалт хийх үеэрээ нисэх онгоц руу чиглэсэн террорист байгууллагын аюул занал, сүрдүүлгийн тухай ярьсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч, “Өнөөдрийг хүртэл олон нийтэд ил болоогүй тагнуулын байгууллагын нууц баримт материал, мэдээлэл цуглуулах арга техник, цэргийн стратегийн талаар нэг ч үг дурсаагүй” хэмээн няцаажээ. АНУ-ын сөрөг хүчнийхэн өнөөгийн Ерөнхийлөгч Доналд Трампыг ОХУ-тай холбоо хамааралтай хэмээн харддаг. Түүнчлэн, өнгөрсөн жилийн арваннэгдүгээр сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд ОХУ-ын хакерууд зориудаар нөлөөлж, улс төрийн туршлагагүй бизнесмэн эрийг ялалт байгуулахад дэмжлэг үзүүлсэн гэх байр суурийг илэрхийлдэг юм.



Хиллари Клинтон улс төрд эргэн ирлээ

Өнгөрсөн жилийн АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшээд ялагдсан Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон өнөөгийн Ерөнхийлөгчийн бодлого шийдвэрийг сөрөх шинэ улс төрийн хүчин байгуулж, улс төрийн хатуу тавцанд дахин гарч ирлээ. Тэрбээр өөрийн твиттер хуудастаа сүүлийн хэдэн сарын турш бодож, бясалган, гэр бүлтэйгээ цагийг өнгөрүүлсний эцэст олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, төрийн албанд нэрээ дэвшүүлэх гэх мэт шалтгааны улмаас “Onwards Together” гэх улс төрийн шинэ хүчнийг байгуулснаа зарласан байна. Одоогоор тус байгууллагын хээ вэб сайтыг нээсэн бөгөөд

өнгөрсөн сонгуульд өөрийг нь дэмжсэн сонгогчдоо нэгдэхийг уриалжээ. Хиллари “Бид сүүлийн хэдэн сард хүмүүс сул дорой нэгнээ дээрэлхэх, гутаан доромжлох, худал хуурмаг, зөрчилдөөн маргаанаас зайлсхийж, илүү шулуун шударгаар Америк орноо хамгаалахын тулд нэгдвэл юу хийж чадах вэ гэдэг талаар эргэцүүлээ. Бид одоо мэдэрч буй хүсэл тэмүүллийнхээ төлөө тэмцэж, тэр эрч хүчээ 2017, 2018 цацшалад 2020 хүртэл хадгалж чадвал юу эснийг бүтээж чадах вэ гэдгээ урьдчилан таамагласан хэрэг” хэмээн твиттертээ жиргэжээ. 2004 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээр Ардчилсан намын дотоод сонгуульд нэр дэвшигч байсан Вермонт мужийн захирагч асан

Ховард Дин ч гэсэн шинэ улс төрийн байгууллага байгуулж байсан түүхтэй. Хиллари одоогоор Доналд Трампт ялагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар ном бичиж байгаа бөгөөд энэ жилдээ багтаан хэвлэлтэд шилжүүлэх аж. Дашрамд сонирхуулахад, 2016 оны сонгуульд Хиллари Клинтон 65.8 сая сонгогчийн санал авсан бол Бүгд найрамдах намын нэр дэвшигч Доналд Трамп 62.9 сая сонгогчийн санал авчээ. Гэвч, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль шууд бусаар буюу сонгогчдын коллегийн гишүүдийн саналаар шийдэгддэг тул ялалт үл хөдлөх хөрөнгийн бизнесмэн Доналд Трампын талд эргэсэн юм. Коллегийн 304 гишүүн Д.Трампыг сонгосон бол Хиллари 227 санал авчээ.

Францын шинэ Ерөнхийлөгч гадаад томилолтоо Германаас эхлүүлжээ

Францын түүхэн дэх хамгийн залуу Ерөнхийлөгчөөр тодроод буй Эммануэль Макрон өнгөрөгч ням гарагт тангаргаа өргөсөн. Тэгвэл тангаргаа өргөснөөс ердөө нэг өдрийн дараа гадаад томилолтоо эхлүүлжээ. Тэрбээр Германы нийслэл Берлин хотноо өчигдөр айлчилж, канцлер Ангела Меркельтэй уулзсан байна. Хоёр орны төрийн тэргүүнүүд Европын холбооны өнөөгийн байдал, түүнийг өөрчлөх шинэ арга замын талаар

ярилцсан аж. Францын Ерөнхийлөгчийн сонгуульд “Үндэсний фронт” намаас нэр дэвшсэн Марин Ле Пенийг ялж сонгогдсон Э.Макрон Европ тивийг арчиж буй популизмтай тэмцэхийн тулд Европын холбоонд түүхэн өөрчлөлт хийх шаардлагатай байгааг уриалж байгаа юм. Харин Германы канцлерын албан тушаалын 10 гаруй жил хашиж буй Ангела Меркель Европын гол цөм

болж буй Франц, Герман хоёр улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэхийн зэрэгцээ Франц Германы тэнхлэгт шинэ түлхэц өгөх бодолтой байгаагаа хоёр талт уулзалтын үеэр дурьдсан байна. Түүнчлэн, Э.Макрон Ерөнхий сайдаа нэрлэсэн билээ. Тэрбээр төвийн үзэл баримтлалт Бүгд найрамдах намын гишүүн, улс төрд төдийлөн танигдаагүй Эдуард Филиппийг даваа гарагт Ерөнхий сайдын албан тушаалд томилсон юм.

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн дотор тусгаарлах шилэн хана, хаалга хийх** ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **100’000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[45]** хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг **2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 11:00 цаг-аас** өмнө Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 11:40 цаг-т нээнэ.

Дотоодын давуу эрх: **“Тооцохгүй”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out



ХОНХНЫ БАЯРЫН ЦАЙЛЛАГА 70-250 МЯНГАН ТӨГРӨГ БОЛДОГ

ГЛАНЧИМЭГ

Энэ хичээлийн жилд улсын хэлжээнд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг 37.5 мянган хүүхэд, есдүгээр ангийг 35.2 мянган хүүхэд төгсөнө. Өөрөөр хэлбэл, 72.7 мянган хүүхэд төгсөн хонхны сүүлийн дугаа цангинуулж, эрдмийн баяраа тэмдэглэнэ гэсэн үг. Жил жилийн хавар төгсөх ангийн сурагч, оюутантай, цаашидад цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт явж буй хүүхэдтэй айлд өрнөдөг халуун сэдвийн нэг нь хонхны баярыг хэрхэн, яаж тэмдэглэх тухай юм. Уг нь БСШУС-ын сайд Ж.Батсуурь өнгөрсөн сарын 21-нд “Эрдмийн баяр тэмдэглэх тухай” А/147 тоот тушаал гаргаж, баяр тэмдэглэхийг хориглосон ч хонхны баярыг далд хэлбэрээр тэмдэглэж буй нь нууц биш болжээ. Уг нь энэ тушаалд “Эрдмийн баяр тэмдэглэх” нэрээр төгсөгчдөөс хуульд заагаагүй төлбөр, хураалт авч, эцэг эх, асран хамгаалагчдад даралт, хүндрэл учруулах, хөдөө хээр, амралт зуслан, голын сав, жуулчны бааз, зочид буудал, цэнгээний газруудад амралт зугаалга, арга хэлжээ зохион байгуулах, архи согтууруулах ундаа хэрэглэхийг бүх шатны боловсролын байгууллагад хориглосон юм. Харин цаасан дээрх тушаал бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж, нөхцөл байдал ямар байгаад иргэд дүн тавьдаг нь нууц биш. Иргэд энэ талаар ямар санал бодолтой явдаг юм бол. Ер нь хонхны баяр тэмдэглэх нь зөв юм уу. Эсвэл буруу зүйл үү. Хэдэн төгрөг зарцуулдаг вэ. Чухал аль арга хэлжээ, юунд их мөнгө зарцуулж байна вэ гэх тэт асуултад иргэд ингэж харууллаа.



Т.Баяраа: Хувцас, гоёл л их мөнгө ордог

/Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны иргэн/

-Манайханд хонхны баяр тэмдэглэж байгаа хүүхэд бий. Сургууль төгсч буй учраас эрдмийн баяраа ёслон тэмдэглэх нь зөв. Найз нөхөд, багш нартайгаа тэмдэглэж, зураг хөргөө авахуулж хадгалан үлдэх нь буруу зүйл биш. Хамгийн гол асуудал нь эдийн засагтаа байгаа юм. Хувцас хунар, гоёл чимэглэлд л их мөнгө ордог доо.



Д.Сэвжиддорж: Цайллага нь 250 мянган төгрөг болсон

/Завхан аймгийн Тэлмэн сумын иргэн/

Д.Сэвжиддорж: Цайллага нь 250 мянган төгрөг болсон

/Завхан аймгийн Тэлмэн сумын иргэн/

-Манай хүүхэд сая Их сургууль төгсч, хонхны баяраа тэмдэглэсэн. Нийллэг цайллагын зардал нь 250 мянган төгрөг болсон. Тэгээд хувцасны мөнгийг нь нэмбэл овоо хэдэн төгрөг болно. Хямарсан үед зардал нь хэт өндөр санагдсан. Харин багшдаа өгч байгаа бэлэг нь тийм үнэтэй байгаагүй. Ер нь хонхны баярыг хэт хавтгайруулж, өргөн дэлгэр тэмдэглэх нь зохисгүй. Харин эрдмийн баяр гэдэг утгаар нь хөнгөн тэмдэглэхэд буруудахгүй болов уу. Ирэх жилээс цаг үе дагаад зардал мөнгө нь буурах биз.



Д.Долгор: Сургууль, цэцэрлэгтээ бүтээн байгуулалт хийдэгт талархдаг

/Хөвсгөл аймгийн Жаргалант сумын иргэн/

Д.Долгор: Сургууль, цэцэрлэгтээ бүтээн байгуулалт хийдэгт талархдаг

/Хөвсгөл аймгийн Жаргалант сумын иргэн/

-Нас насандаа тохирсон байдлаар тэмдэглэж баярлах нь зөв. Хүүхэд юуг ямар хэмжээнд сурч мэдсэнээ тайлагнаж баярлах хэрэгтэй. Цэцэрлэгийн насны хүүхдийн баярыг хийхдээ эцэг эх нь их хэмжээний мөнгө гаргаж найрлаж цэнгэдэг нь буруу. Харин цэцэрлэг, сургуульдаа бүтээн байгуулалт хийж үлдэх нь зөв гэж хувьдаа бодож, талархдаг. Түүнээс биш наргиж цэнгэх, ууж идэх асуудлыг хүлээн зөвшөөрдөггүй. Хэт өндөр зарлагатай, эдийн засгийн үр ашиггүй зүйлд мөнгө зарцуулах дургүй.



П.Сүнжидмаа: Эрдмийн баяр учраас хүүхдэд дарамтгүй байгаасай

/Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны иргэн/

П.Сүнжидмаа: Эрдмийн баяр учраас хүүхдэд дарамтгүй байгаасай

/Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны иргэн/

-Манайд хонхны баяр тэмдэглэж байгаа хүүхэд байхгүй. Бүгдээрээ сургуулиа төгссөн. Хамгийн бага нь 22 настай. Одоо ач зээ нар байна. Биднийг хүүхдээ сургууль төгсгөж байх үед хонхны баяр гэж айхтар шуурч байсан нь үгүй. Тухайн үедээ багш нараа хөнгөхөн баярлуулж байсан. Ийм учраас тэгтлээ их хүнд дарамт мэдрээгүй. Гэтэл одоо өргөн тэмдэглэдэг болжээ. Эдийн засгийн хувьд болон заавал ямар нэгэн байдлаар дарамттай, бүр нэр төрийн хэмжээний асуудал болж хувирсан байна. Энэ нь хүүхдүүдэд их муу нөлөөтэй. Сурч мэдсэнээ тайлагнахаас илүүтэй юу өмсч зүүснээрээ уралдаж байна. Хүүхэд төгсч буй учраас хонхны баяр тэмдэглэх нь зөв. Гэхдээ эрдмийн баяр учраас хүүхдэд дарамтгүй, жинхэнэ баяр хөөр байгаасай гэж хүсдэг. Би хувьдаа ерөнхий боловсролын болон их, дээд сургууль төгсч буй хүүхдүүд энэ баярыг тэмдэглэх нь зөв, харин цэцэрлэгт бол илүү зан гэж боддог. Бага насны хүүхдүүд энэ баярын утга учрыг ойлгох ч үгүй. Эцэг эхчүүд нь мөнгө гаргаж, баярлаж хөөрөөд байдаг. Бусдын дор орохгүй гэсэндээ тав, арван цааснаас болж эцэг эх ч хоорондоо маргадаг.



С.Оргилболд: Боломж бололцоогоороо хонхны баяр тэмдэглэх нь зөв

/Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны иргэн/

С.Оргилболд: Боломж бололцоогоороо хонхны баяр тэмдэглэх нь зөв

/Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны иргэн/

-Хонхны баяраа яаж тэмдэглэх нь тухайн хүүхдийн ар гэрийн боломж бололцоо, амьдралын нөхцөл байдлаас шалтгаалдаг. Би хувьдаа боломжоороо тэмдэглэх нь зөв гэж боддог. Миний ажигласнаар хонхны баяр тэмдэглэх эсэх нь тухайн ангиасаа их шалтгаалдаг. Нийтгэч, хамт олонч ангийн хүүхдүүд хорьсон ч, хориогүй ч ил, далд хэлбэрээр тэмдэглэж л байдаг. Харин нийтгэч бус ангийн хүүхдүүдийн санаа нийлэхгүй, тал тал тийшээ тарж явчихаад олигтой тэмдэглэж чадаагүй. Бүр тэмдэглэж чадахгүй өнгөрөх нь ч бий. Би 2015 онд сургуулиа төгссөн. Тухайн үед хувцас хунартайгаа нийлээд 500 мянган төгрөгийн зардал гарч байсан. Охидынх арай илүү л дээ. Дээд хийлгэсэн энэ тэр гээд хувцасны зардал нь өндөр байдаг.

н.Баасанхүү: Хориглосон ч хонхны баяр тэмдэглэнэ

/Өвөрхангай аймгийн Уянга сумын иргэн/



-Манайд энэ жил сургууль төгсч байгаа хүүхэд бий. Одоогоор хонхны баяр тэмдэглэхэд тэдэн төгрөг хэрэгтэй гэж яриагүй байгаа. Хөдөө газар учраас дарамт, татаас нь бага байх болов уу. Уг нь салбарын сайдын тушаал гарч, хонхны баярыг тэмдэглэхийг хориглосон л гэсэн. Гэхдээ тэмдэглэх нь ойлгомжтой. Ер нь хонхны баярыг тодорхой хэмжээгээр тэмдэглэсэн нь зөв.

Г.Зоригтбаатар: Цэцэрлэгт хонхны баяр тэмдэглэх хэрэггүй

/Сэлэнгэ аймгийн Баянгол сумын иргэн/



-Манай хүүхэд энэ жил ерөнхий боловсролын сургууль төгсч байгаа. Энэ сарын 19-нд хонхны баяр нь болно. Одоогоор 70 мянган төгрөг л татна гэсэн. Үүнээс өмнө нь ангиараа фондын мөнгө гэж цуглуулсан. Түүнийгээ бас зарцуулна. Түүнээс биш хөдөөнийхөн чинь мөнгө гаргах дургүй шүү дээ. Яагаад гэвэл, нэг айлд олон хүүхэд бий. Манайх гэхэд дөрвөн хүүхэдтэй. Том хүүгийнхээ хонхны баярыг энэ жил хийлээ гэхэд дахиад гурван хүүхэд

бий. Ерөнхий боловсролын болон Их, дээд сургууль төгсч буй хүүхдүүд хонхны баяр тэмдэглэхэд буруудах зүйл үгүй. Харин цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэд хонхны баяр тэмдэглэх хэрэггүй. Тэр хүүхэд өсч томорно. Тиймээс сургууль төгсөх үедээ л хонхны баяр тэмдэглэх хэрэгтэй. Түүнээс биш юу болоод байгааг нь сайн ойлгохгүй хүүхдэд хонхны баяр тэмдэглэнэ гэж юу байх вэ. Энэ чинь гэр бүлд дарамт үүсгэдэг.

НИЙГЭМ

ТОМИЛОЛТ

“НАМЧИРХАЛ, УЛСТӨРЖИЛТӨӨС ҮҮДЭЖ



ДАРХАН-УУЛ АЙМАГ



Аймгийн Засаг даргын тамгын газрын 7037-1212 утсанд ирсэн иргэдийн хүсэлтийн дагуу аймгийн Цагдаагийн газар энэ оны 4-5 дугаар сард хоёр удаа цахим тоглоомын газруудад хяналт шалгалтыг хийсэн байна. Шалгалтаар Дархан суманд үйл ажиллагаа явуулдаг 12 цахим тоглоомын газар, таван

интернет кафе, Шарын гол суманд үйл ажиллагаа явуулдаг нэг цахим тоглоомын газар хамрагдаж дөрвөн зөрчлийг илрүүлж бүртгэлийн хугацаа дууссан байгууллагын үйл ажиллагааг зогсоожээ. Улмаар ЗХТХ-ийн 42.2-д зааснаар 114.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч ажилласан байна.

“Спортлог Дарханчууд” дэд хөтөлбөрийг баталлаа

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар “Спортлог Дарханчууд” дэд хөтөлбөрийг хэлэлцэн баталжээ. Төрөөс биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд анхаарч нийтийн биеийн тамирыг бүх нийтийн үйлс болгох талаар арга хэмжээ авч байгаа боловч хүн амын бие бялдрын соёл, эрүүл аж төрөх хэв маягийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй.

Хэргийгээр Дархан-Уул аймгийн спортын мэргэжлийн баг, тамирчид тив дэлхий, улсын чанартай уралдаан тэмцээнүүдэд өндөр амжилт гаргасаар ирсэн боловч энэ амжилтыг улам нэмэгдүүлэх, мөн энгийн иргэдийн дунд биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлага байгаа аж. Тиймээс “Спортлог Дарханчууд” дэд хөтөлбөрийг баталж, энэ хүрээнд Өсвөрийн шигшээ багийг байгуулж, шилдэг ур чадвартай тамирчдыг бэлтгэн гаргахаар болсон байна. Мөн жил бүр багуудын насанд хүрэгчдийн дунд “Дархан–Спорт наадам”-ыг хоёр насны ангиллаар, спортын таван төрлөөр зохион байгуулах, Азийн Хүүхдийн спортын их наадамд оролцох тамирчдыг өндөр төвшинд бэлтгэн оролцуулахаар төлөвлөсөн байна.

Үүгээр зогсохгүй байгууллага бүрт спортын хамтлаг бий болгож, урамшууллын тогтолцоог бий болгох, байгууллагуудад албан хаагчдын биеийн ерөнхий хөгжлийн тогтоож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах, төвшин тогтоох сорилын үр дүнг тооцох, нас биеийн онцлогт тохирсон зөвлөмж боловсруулан хүргүүлэх, мөрдүүлэх, арга хэмжээ зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нийтийн биеийн тамирын өдөрлөг, хүн амыг эрүүл чийрэг бие бялдартай иргэн болгож төлөвшүүлэхэд чиглэсэн нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулж, хамрах хүрээг өргөтгөх зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулах юм байна.

ОРХОН АЙМАГ

Эцэг, эх байх эрхийг хасах албан тоот явуулжээ

Орхон аймгийн Цагдаагийн газрын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх алба”, ХГБЗХГ гурван гэр бүлийн гурван хүүхдийн хамгааллын асуудлаар шүүхийн байгууллагад эцэг, эх байх эрхийг нь хасах тухай албан тоот явуулжээ. Учир нь хүүхдээ үл хайхрах хүчирхийлэлд өртүүлж хараа хяналтгүй орхиж архи ууж буй дээрх гурван гэр бүлийн эцэг эхчүүдэд удаа дараа сануулсан ч хүүхдээ харж хамгаалахгүй байгаа тул дээрх арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна. Харин хүүхдүүдийг нь асрам-

жийн газарт өгөх эсэх талаар судалж байгаа гэнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилдэг тус аймаг дахь “Гүр хамгаалах” байранд өнөөдрийн байдлаар зургаан хүн байгаагийн дөрөв нь бага насны хүүхэд байна. Аймгийн ХГБЗХГ-т өдөрт дунджаар нэгээс хоёр хүн хүчирхийлэлтэй холбоотойгоор ханддаг бөгөөд “Гүр хамгаалах байр”-нд хандаж буй хоёр хүн тутмын нэг нь хүүхэд байгаа ажээ.

Он гарсанаас хойш Орхон аймагт 28 иргэн тус төвөөр үйлчлүүлжээ.

ДУНДГОВЬ АЙМАГ

Эстрад дууны уралдааныг МУГЖ Х.Төмөрбаатарын нэрэмжит болгов

Дундговь аймгийн ардын авьяастнууд 1960-1990-ээд оны үед ард түмний дунд хит болж байсан эстрад дууг сэргээн дуулж уралдах гэж байна. Энэ уралдааныг МУГЖ дуучин Х.Төмөрбаатарын нэрэмжит болгон зохион байгуулна. Аймгийн Төв Халхын дуулалт жүжгийн театр дуу хуурын өлгий нутгийн урлагийн хойч үе, ардын авьяастнуудыг тодруулж, тэднийг дэмжин хөгжүүлэхээр дууны уралдааныг зохион байгуулдаг. Ингэхдээ тухайн уралдааныг төрөлх нутгаасаа төрсөн гавьяатуудаараа овоглодог нь тэдний үйлс алдрыг алдаршуулж, хүндэтгэл үзүүлэх зорилгыг агуулдаг байна.

Үрд нь Монгол Улсын Ардын жүжигчин А.Дашпэлжээ, МУГЖ П.Чулуунцэцэг, А.Нэргүй нарын нэрэмжит ургын болон зохиолын уралдааныг зохион байгуулж

байсан бол энэ уралдааныг эстрад дууны төрлөөр МУАЖ, Хөдөлмөрийн баатар Г.Хайдавын хүү МУГЖ Х.Төмөрбаатарын нэрэмжит болгож ийнхүү зарлажээ.

Уралдаанд 16-40 насны иргэд оролцоно. Оролцогчид эхний шатанд 1960-1990-ээд оны үеийн эстрадын шилдэг дуунуудыг сэргээн өөрсдөө сонгож дуулах бол удаах шатанд удирдамжид заасан дуунаас сонгож дуулах юм байна. Үүнд “Бүсгүй минь байр”-нд хандаж буй хоёр хүн тутмын нэг нь хүүхэд байгаа ажээ. Он гарсанаас хойш Орхон аймагт 28 иргэн тус төвөөр үйлчлүүлжээ.

Ч.Цогтбаатар: Уул уурхайн тухай хуулийг шинээр боловсруулж, УИХ–д өргөн барина

/УУХУЯ-ны Уул уурхайн бодлогын газрын ахлах мэргэжилтэн/

-Засгийн газрын 2016-

2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Уул уурхайн салбарын эрхзүйн орчинг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлагдсан. Үндсэн чиглэлийн хүрээнд уул уурхайн салбартай холбоотой хэд хэдэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тусгагдсан байдаг. Тухайлбал, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга, , Үйлдвэрлэл технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Уул уурхайн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуульд

өөрчлөлт оруулах хуулийн төслийг давхар боловсруулах ч шаардлага гарна.

Б.Баатарсүх: Засгийн газар Хүнд үйлдвэрийн салбарт дөрвөн том төсөл хэрэгжүүлнэ

/УУХУЯ-ны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга/

-Монгол Улсын хүнд үйлдвэрийн салбар хөгжлийнхөө эхлэл үед байна гэж ойлгож болно. Шинэ Засгийн газраас Зэсийн баяжмал боловсруулах

...Би түрүүнд илтгэлдээ дурьдсан.

Бид олон жил нэг асуудлаа ярьж байна. 20 жил, 40 жил яригдсан төсөл хөтөлбөрүүд байна. ТЭЗҮ хийж байгаад л олон удаа нэг төслөө ярьдаг. Хийсэн ТЭЗҮ-г нь аваад үзвэл өртөг зардал нь нэмэгдчихсэн байх жишээтэй. Хүнд үйлдвэрийн салбарт хамгийн эхэнд эрхзүйн орчин, салбарын тогтолцоог нэлээд анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэгдсэн бодлого, тогтолцоогүй байна гэсэн үг...

нэмэлт өөрчлөлт оруулах юм. Мөн уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн орчныг олон улсын жишигт нийцүүлэхийн тулд Уул уурхайн тухай хуулийг шинээр боловсруулж, УИХ-д өргөн барина. Энэхүү хуулийн үзэл баримтлал нь батлагдсан. Одоогийн байдлаар хуулийн төсөл боловсруулах шатандаа явж байна. Хэлэлцүүлгийн үеэр уул уурхайн компаниудтай холбоотой асуудал яригдлаа. Уг асуудлыг тодорхой хуулийн хүрээнд шийдэж байгаа. Хэрвээ компани байгаль орчинд ноцтой хохирол учруулсан бол мөнгөн торгуулиас гадна эрүүгийн хэрэг үүсгэнэ гэдгийг анхаарч байхад, Уул уурхайн салбар ба орон нутгийн хамтын ажиллагаа гэсэн гурван сэдвийн хүрээнд чуулга уулзалтад оролцогчид хэлэлцүүлэг өрнүүлээ. Хэлэлцүүлгийн үеэр төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлгүүд салбарын хөгжилд анхаарч, цаашдын үйл ажиллагаанд нарийн тусгах санал, санаачлагаа хэлсэн юм. Энэ үеэр бид чуулгад оролцогч УИХ-ын гишүүд болон бусад албаны төлөөллүүдтэй уулзаж, ярилцлаа.

үйлдвэр, Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр, Газрын тос боловсруулах үйлдвэр, Төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэх гэсэн дөрвөн том төслийг хэрэгжүүлэхээр зорьж байна. Дээрх төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол Улсад эдийн засгийн хувьд өндөр үр ашигтай. Тухайлбал, Импортын хэмжээнэгтэрбумам.доллараар буурч, гадаад худалдааны эдийн засгийн ашиг нэмэгдэнэ. Бид жилд нэг тэрбум ам.доллараар нефть бүтээгдэхүүн худалдаж зогсоосноор ам.долларын савлагааг зогсоож чадах юм. Мөн 2800 гаруй шууд, 3000 гаруй шууд бус ажлын байр нэмэгдэнэ. Валютын гарах урсгал 25 орчим хувиар буурч, ам.долларын ханш 30 хувиар буурах боломж бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 30 орчим хувиар нэмэгдэх орчин бүрдэх юм. Түүнчлэн улсын



болон орон нутгийн төсөвт татвар хураамж хэлбэрээр жил бүр ойролцоогоор 300 сая ам.долларыг төвлөрүүлэх боломжтой. Дээрх төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 6.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй. Одоогоор Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөлд Энэтхэг улсын хөнгөлөлттэй зээлээр 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг шийдлээ. Зэс боловсруулах үйлдвэрт 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Бид одоогийн байдлаар судалгаа хийж, хөрөнгө оруулагчаа хайж байна. Нэг эерэг зүйл ажиглагдаж буй нь гадаадын хөрөнгө оруулагчид хүнд үйлдвэрийн салбарыг их сонирхож байгаа. Тухайлбал, Зэс боловсруулах үйлдвэрийн төсөлд хамтран ажиллах саналыг Герман улсын хоёр, БНХАУ-ын дөрвөн компани тавьсан. Салбар яамнаас Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр зорьж байна. Түүнээс гадна нэн тэргүүнд үйлдвэржилтийн зургийг гаргана. Мөн хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогын бичиг баримтыг боловсруулахаар ажиллаж байна.

Г.Тэмүүлэн: Эрхзүйн орчин, салбарын тогтолцоог анхаарах шаардлагатай

/УИХ-ын гишүүн/

-Уул уурхайн салбар үүсч, хөгжсөний 95 жилийн ойн хүрээнд Төвийн бүсийн чуулганыг Эрдэнэт хотод зохион байгууллаа. Чуулганы салбар хуралдаанаар хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн гарц шийдлийг ярилцсан. Би түрүүнд илтгэлдээ дурьдсан. Бид олон жил нэг асуудлаа ярьж байна. 20 жил, 40 жил яригдсан төсөл хөтөлбөрүүд байна. ТЭЗҮ хийж байгаад л олон удаа нэг төслөө ярьдаг. Хийсэн ТЭЗҮ-г нь аваад үзвэл өртөг зардал нь нэмэгдчихсэн байх жишээтэй. Хүнд үйлдвэрийн салбарт хамгийн эхэнд эрхзүйн орчин, салбарын тогтолцоог нэлээд анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэгдсэн бодлого, тогтолцоогүй байна гэсэн үг. Шулуухан хэлэхэд, салбарын бодлогын хүрээн дэх улстөржилт, намчирхлын асуудлаас болж салбарын бодлого тогтвортой байж чаддаггүй, хэрэгждэггүй. Ийм л нөхцөл байдал үүссэн. Үүнийг эцэслэх зайлшгүй шаардлагатай. Манай улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжээд 20 гаруй жил болж байна. Энэ хугацаанд УИХ-аар маш олон стратегийн төсөл орж, хэлэлцэгдэж байгааг иргэд мэднэ. Үүнээс ганцхан Оюутолгойн төсөл, хөтөлбөр УИХ-аар батлагдсан. Энэ бүхний цэгцлэх хэрэгтэй.

1000 инженерийн зөвлөгөөн боллоо

Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК жил бүр үйлдвэрийнхээ бүтээмж, инновацийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үр дүнг дүгнэх, үйлдвэрийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд мэргэжилтнүүдийн үзэл бодлыг тусгах, оюуны бүтээлийг дэмжин сурталчлах зорилгоор “1000 инженерийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ удаагийн зөвлөгөөн энэ сарын 15-нд Эрдэнэт хотод болж өндөрлөлөө. Тус зөвлөгөөнийг

НИЙГЭМ

УУЛ УУРХАЙН САЛБАР ХӨГЖИЖ ЧАДАХГҮЙ БАЙНА”



Д.Зоригтхүү: Тээрэм солих хугацаанд үйлдвэрийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх боломжтой

/Баяжуулах фабрикийн Шинэ техник технологи хариуцсан Тэргүүлэх тэрэгжилтэн, Техникийн ухааны доктор/

-Манай баяжуулах фабрик 1989 онд ашиглалтад орсон дөрвөн тээрмийг 2018-2019 онд солино. Тээрэм солих хугацаа бол 2-3 сар гэж тооцож байгаа. Хамгийн гол ажлыг гүйцэтгэж

буй тээрмүүд зогсохоор хүдэр бэлтгэх боломжгүй болно. Үүнээс шалтгаалжээс, молибден ялгаж чадахгүй болно. Мөн тээрэм зогсох хугацаанд 10-15 сая ам.долларын мөнгөн урсгал тасалдах нөхцөл үүснэ. Үүнээс урьтаж хүдэр бэлтгэлийн хүчин чадлаа нэмж чадвал тээрэм солих хүртэл хугацаанд одоогийн үйл ажиллагаагаа хадгалаад явах боломжтой. Энд хоёр шийдэл бий. Нэгдүгээрт, өндөр даралтын нунтаглагч бул гэж технологийг хэрэгжүүлнэ. Одоогийн байдлаар манай улсад хараахан орж ирээгүй. Уг технологийг хэрэгжүүлснээр хүдэр бэлтгэх хүчин чадлаа нэмэх, цахилгаан эрчим хүч хэмнэх зэрэг давуу талтай.

С.Нармандах: 1.5 сая ам.доллар хэмнэх боломжтой

/Хөгжлийн хэлтсийн уулын инженер, Техникийн ухааны магистр/

-Манай үйлдвэрийн хүдрийн ил уурхай баяжуулах фабрикийн хооронд хүдрийн агуулгын зөрүү гардаг. Энэ агуулгын зөрүүг багасгахын тулд гурван багц судалгааны ажил хийлээ. Үүний нэг судалгааны ажлаа өнөөдөр танилцууллаа. Уг судалгаа нь агуулгын зөрүүнд ил уурхайн цооногоос авсан дээжлэлт хэрхэн нөлөөлж байна, түүнд алдаа буй эсэхийг шалгах зорилготой. Судалгааны үр дүнд дээж бэлтгэх процесст хоёр шаттай шинэчлэлт хийснээр 1.5 сая ам.доллар хэмнэх боломж бүрдсэн. Дээж авах хэрэгсэл болон дээж бэлтгэх процесст 50-60 мянган ам.долларын өртөг бүхий нэг бутлуур нэмж тавьснаар 1.5 сая ам.доллар хэмнэх боломжтой.

нээж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн “Инженерийн боловсрол эзэмшинэ гэдэг нэр төрийн хэрэг байдаг билээ. Дэлхий ертөнцөд инженер хүний үнэлэмжийг дээшлүүлэхийн төлөө улс орон бүр өөрийн гэсэн бодлоготой үйл ажиллагаа явуулдаг. Түүний дотор Засгийн газар болон холбогдох байгууллагууд инженерүүдээ дэмжиж, инженерүүдийнхээ бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг өргөн хүрээнд явуулдаг билээ. Уул уурхайн баяжуулах Эрдэнэт үйлдвэр 1000 инженерийн зөвлөгөөнийг тав дахь жилдээ зохион байгуулж байна. Зөвлөгөөнөөр бид инженерүүдийнхээ сэтгэн

бодох ур чадварыг нэмэгдүүлэх, бүтээлийг нь үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийг нь хангах ажлыг үе шаттайгаар хийдэг. Цаашид шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, улс орны хөгжилд инженерүүдийн оролцоог улам нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, бодитой тусалцаа үзүүлнэ. Өнөөдрийн зөвлөгөөн Монгол Улсад уул уурхайн салбар үүсч, хөгжсөний 95 жилийн ой давхцаж байгаа. Эрдэнэт үйлдвэрийг 40 гаруй жил ажиллахад шинжлэх ухааны үндэстэй шийдлийг гаргаж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэр шинжлэх ухааны холбоог бэхжүүлэхэд, сэтгэл зүрх, цаг

зав гарган ажилласан үе үеийн инженерүүдэд ажлын амжилт хүсье” гэв. Тус зөвлөгөөний хүрээнд “Эрдэнэт үйлдвэр ХХК-д тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт илгээлийн уралдаан зарлажээ. Уралдаанд хөгжлийн бодлого, хүний нөөцийн бодлого, техник, технологийн бодлого, ХАБЗАБОХ бодлого гэсэн таван үндсэн чиглэлээр 50 гаруй илтгэл ирсэн байна. Тав дахь жилдээ зохион байгуулагдаж буй “1000 инженерийн зөвлөгөөн”-ний үеэр чиглэл бүрт шалгарсан шилдэг таван илтгэгч илтгэлээ танилцуулсан юм. Энэ үеэр илтгэгчидтэй цөөн хором ярилцлаа.



ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: БОЭТ-д Гемодиализ /бөөрний дутагдалын/ аппарат
Тендер шалгаруулалтын дугаар: OP-162/2017

Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос **БОЭТ-д Гемодиализ /бөөрний дутагдалын/ аппарат** нийлүүлэх тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50000 /тавин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх**

Санхүүгийн тайлан: **2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлэх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнтэй дүйцэх эсвэл түүнээс дээш байх**

Ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төрлийн барааг нийлүүлсэн туршлагатай байх**

Тусгай зөвшөөрөл: Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх

Тендерийн хамт 750,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг цахимаар гарган ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 06-р сарын 15-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 06-р сарын 15-ны 09 цаг 30 минутад** цахимаар Орхон аймгийн ЗДТГ-ын Нэг цонхны үйлчилгээ, ОНӨГ-ын Сургалт мэдээллийн танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас:70358570**

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Бүсийн оношлогоо эмчилгээний төвд дижитал рентген оношилгооны аппарат
Тендер шалгаруулалтын дугаар: OP-156/2017

Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Бүсийн оношлогоо эмчилгээний төвд дижитал рентген оношилгооны аппарат** нийлүүлэх тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50000 /тавин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх**

Санхүүгийн тайлан: **2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлэх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнтэй дүйцэх эсвэл түүнээс дээш байх**

Ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төрлийн барааг нийлүүлсэн туршлагатай байх**

Тусгай зөвшөөрөл: Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх

Тендерийн хамт 2,000,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг цахимаар гарган ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 06-р сарын 15-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 06-р сарын 15-ны 09 цаг 30 минутад** цахимаар Орхон аймгийн ЗДТГ-ын Нэг цонхны үйлчилгээ, ОНӨГ-ын Сургалт мэдээллийн танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас:70358570**

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: БОЭТ-д Наркозны аппарат /унтуулга/
Тендер шалгаруулалтын дугаар: OP-166/2017

Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос **БОЭТ-д Наркозны аппарат /унтуулга/** нийлүүлэх тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50000 /тавин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх**

Санхүүгийн тайлан: **2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлэх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнтэй дүйцэх эсвэл түүнээс дээш байх**

Ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төрлийн барааг нийлүүлсэн туршлагатай байх**

Тусгай зөвшөөрөл: Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх

Тендерийн хамт 750,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг цахимаар гарган ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 06-р сарын 15-ны өдрийн 09 цаг 30 минутаас** өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 06-р сарын 15-ны 10 цаг 00 минутад** цахимаар Орхон аймгийн ЗДТГ-ын Нэг цонхны үйлчилгээ, ОНӨГ-ын Сургалт мэдээллийн танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас:70358570**

ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр +18

Шөнө +14



Нөгөөдөр

Өдөр +17

Шөнө +6

Өдрийн зурхай

ХАВРЫН АДАГ ХӨХ
ЛУУ САРЫН ЕСӨН УЛААН
МЭНГЭТЭЙ ХӨХ ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:
05.17-20.27



Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлнийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, хур оруулах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ



Б.СУМЬЯА

Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo-2017” тэмцээний “Байгаль орчин” төрөлд дэд байр эзэлсэн цуврал зургийн нэг нь энэ.

БНХАУ-ын Сычуан мужийн Бифеншиа хулсны баавгай

үржүүлгийн газарт байгальд нь тавихад бэлэн болсон бяцхан пандаг сагсанд хийн жинлэж буй байдал ийн дүрслэгджээ.

Насанд хүрсэн пандагийн жин нь 100-135 кг-ын хооронд хэлбэлздэг байна. Харин бяцхан панда 8 кг жин татаж буй байдал зурагт дүрслэгджээ.

Хар цагаан өнгөтэй хулсны баавгайнууд БНХАУ-ын бэлгэдэл. Тэр ч үүднээс устаж үгүй болохдоо тулсан баавгайн төрлийг өсгөж үржүүлэхэд тус улсаас ихээхэн анхаарал тавьдаг аж. Нэг тоон баримт дурьдахад л, дэлхийн нийт зэрлэг хулсны баавгайн гуравны хоёр нь зөвхөн Сычуан мужийн

хулсан ойд амьдардаг байна. Ийн анхаарч ажилласны дүнд панда эдүгээ устаж үгүй болох эрсдэл бага болжээ. Энэ зургийн дэлхийн 75 гаруй орноор хэрэн хэсүүлчилж, бүтээлээ туурвисан “National Geographic” сэтгүүлийн гэрэл зурагчин Эми Витале авчээ.

ДУУЛГАХ СОНИН

Виктор Лебедев ЗОДОГ ТАЙЛЛАА

ОХУ-ын чөлөөт бөхийн шигшээ багийн хөнгөн жингийн шилдэг бөх Якутын Виктор Лебедев зодог тайлахаар боллоо. “Москва-2010”, “Стамбул-2011” ДАШТ-ий аварга, “Хернинг-2009”, “Лас Вегас-2015”-ын хүрэл медальт, 2010, 2011 оны Дэлхийн цомын аварга, “Баку-2015” Европын анхдугаар наадмын аварга, ЕАШТ-ий хүрэл медальт, Иван Ярыгиний “Алтан Гран”-гийн нэг алт, нэг мөнгө, хоёр хүрэл медальт, ОХУ-ын гавьяат тамирчин өдгөө 29 настай Лебедев Якутын хотын захирагч Айсен Николаевын зөвлөхөөр томилогдож, тамирчны замналаа өндөрлүүлэхээр шийджээ. “Рио-2016” олимпын наадмаас хойш ганц ч удаа дэвжээн дээр гараагүй тэрбээр хөнгөн жингийн бөхчүүдээс ОХУ-ын аварга шалгаруулах тэмцээнд хамгийн олон удаа буюу зургаан удаа түрүүлсэн юм.



Олон улсын ТЕАТРЫН ӨДРИЙГ тэмдэглэнэ

1977 онд Москва хотод болсон Олон улсын музейн зөвлөлийн XI ерөнхий бага хурлаар жил бүрийн тавдугаар сарын 18-ны өдрийг “Олон улсын музейн өдөр” болгон тэмдэглэх шийдвэр гарснаар уг өдрийг дэлхий нийтээр тэмдэглэн ирсэн уламжлалтай. Манай улс Олон улсын музейн өдрийг 1998 онд анх тэмдэглэсэн бөгөөд 2003 онд Олон улсын музейн зөвлөлийн Монголын Үндэсний хороо байгуулагдсанаар тасралтгүй 14 жил тэмдэглэж байна. Энэ өдрүүдэд дэлхийн музейнүүд тодорхой сэдвийн дор олон нийтэд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулдаг. Энэ жил тус өдрийг нийгмийн хөгжлийн тусын тулд дэлхийн бүх хүмүүсийг

эвтэй найртай оршиход уриалах зорилгоор “Музей ба ээдрээтэй түүх: нээлттэй ярилцъя” сэдвийн дор зохион байгуулна.

Энэ жилийн Монгол Улс дахь Олон улсын музейн өдрийг тэмдэглэх үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулагчаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар, хамтран зохион байгуулагчаар Олон улсын музейн зөвлөлийн Үндэсний хороо, Монголын Үндэсний музей ажиллаж байна. Олон улсын музейн өдрөөр “Музей ба ээдрээтэй түүх: нээлттэй ярилцъя” сэдвийн хүрээнд түүх, соёлын үзэсгэлэн, эрдэм шинжилгээний бага хурал, хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулах аж.

Бидэнд тохиолдсон



ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД



Энхүүнээ Бб.

Эмээ өвөөгийндөө ирээд эмээтэйгээ жаахан буу халав. Тэгсэн чинь эмээ “Би өвөөтэй чинь нэг их дуугарахгүй байгаа” гэж байна. Би гайхаад л “яасан юм бэ” гэсэн чинь “Ойрдоо хүмүүс ирэхээр хоол болохоос өмнө архиа түрүүлээд үгэнд орохгүй байхаар нь үг дуугарахаа больсон. Тэгсэн чинь одоо гэмшээд, энэнээс л нэг болоод гээд одоо уухгүй байгаа биз дээ” гээд нээх хөөрхөн инээдэг юм даа. 80 хүрч байж бие биендээ эрхэлсээр л байх юм. Хөөрхөн юм аа.

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ




Манай эмнэлэг дотор 5 цул, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танад:

- Ган болон мөнгөн зүү, шахилгаан зүү
- Хануур, сав соруул
- Шарлаа
- Бумба төөнө засал
- Халуун чулуу, давсан халуун жин засал
- Эмчилгээний цэгэн барил
- Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн барил зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ
Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг
Улаанбаатар их
дэлгүүрийн баруун талд
"Ганзүү" эмнэлэг
/Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III
хороолол, 28
дугаар сургуулийн
баруун талд
"Ганзүү" эмнэлэг
/Хэвтүүлэн
эмчилнэ/

